

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ
Шинэчилсэн найруулга**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1. Энэ хуулийн зорилт нь хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, эрсдэлт нөхцөл байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, хүүхэд хамгааллын удирдлага, зохион байгуулалтыг эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомж

1. Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

3. Хүүхэд хамгааллын талаар тогтоосон хуулиуд хоорондоо зөрчилдвэл хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илүү хамгаалсан хуулийг хэрэглэнэ.

1.3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа Монгол Улсын иргэн, түр болон байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд энэ хууль үйлчилнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд Монгол Улсын хилийн гадна байгаа Монгол Улсын харьяат хүүхэд болон гадаадын иргэнд үрчлүүлсэн хүүхдэд энэ хууль үйлчилнэ. Гадаадын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх асуудлыг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай, Монгол Улсын хилийн гадна байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх асуудлыг тухайн улс дахь Дипломат төлөөлөгчийн газар, Консулын албатай хамтран хэрэгжүүлнэ.

3. Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 21 нас хүртэлх хүнд энэ хууль үйлчилнэ.

4. Хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 18 насанд хүрсэн хүний зөвшөөрснөөр энэ хуульд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээг түүнийг 21 нас хүртэл үзүүлж болно.

1.4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.1."хүүхэд хамгаалал" гэж хүүхдийг хүчирхийлэл, үл хайхрах байдал, мөлжлөг, тэвчишгүй хөдөлмөрийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалах, хүүхдийн эрхийг хангахтай холбоотой хууль тогтоох, захиргааны болон бусад арга хэмжээний олон талт, цогц тогтолцоог;

1.2."хүүхэд хамгааллын үйлчилгээ" гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, түүнд шуурхай тусlamжийн үйлчилгээ үзүүлэх, нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохос урьчдилан сэргийлэх үйл ажиллагааг;

1.3."эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд" гэж хүчирхийлэлд өртсөн; бие махбодь, сэтгэл санаа, ёс суртахуун, оюун ухаан, хөгжилд нь хохирол учрах аюултай нөхцөл байдалд байгаа; бүтэн өнчин; гамшиг, гамшигийн онцгой нөхцөл байдалд байгаа хүүхдийг;

1.4."хүчирхийлэлд өртсөн хүүхэд" гэж бие махбодийн шийтгэл, үл хайхрах байдал, мөлжлөг, бэлгийн болон сэтгэл санааны дарамтын хохирогч болсон хүүхдийг;

1.5."бүтэн өнчин хүүхэд" гэж Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасныг;

1.6."гамшиг" гэж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасныг;

1.7. "гамшигийн онцгой нөхцөл байдал" гэж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.19-д заасныг;

1.8."хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд" гэж гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээсэн, гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогч болсон, үрчлэлт, гэр бүл цуцлалт болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн хүүхдийг;

1.9."хүүхдийн эрхийн төлөөлөл" гэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох, хүүхэдтэй холбоотой шийдвэр гаргах ажиллагаанд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахыг;

1.10."нийгмийн ажилтан" гэж сум, хорооны нийгмийн ажилтан болон хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдэд ажиллаж байгаа нийгмийн ажилтныг;

1.11."хамтарсан баг" гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасныг;

1.12."хүүхдийн эрхийн хууль зүйн хороо" хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд шаардлагатай тусlamж, үйлчилгээний талаар

шийдвэр гаргах, гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн орон тооны бус нэгжийг;

1.13."асралт гэр бүл" гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хүмүүжүүлэхээ хүлээн зөвшөөрсөн, энэ хуульд заасан шаардлагыг хангасан гэр бүлийг;

1.14."хүүхэд хамгааллын хэрэг (кейс)-ийн менежмент" гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээний хэрэгцээг тодорхойлох, үе шаттайгаар нийгмийн ажил, боловсрол, эрүүл мэнд, халамж, хууль зүйн туслалцаа, бусад үйлчилгээг тогтолцоот хандлагаар шийдвэрлэх хамтын арга, ажиллагааг;

1.5 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын зарчим

1.Хүүхэд хамгаалалд дараах зарчмыг баримтална:

1.1.хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, шийдвэр, үйл ажиллагаанд хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих;

1.2.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийг асран хамгаалах чадваргүй, хүсэлгүй эсхүл тусlamж шаардлагатай тохиолдолд төр хөндлөнгөөс оролцох;

1.3.хүүхэд хамгаалал нь гэр бүл төвтэй, дагнасан, шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй байх;

1.4.хүүхдийг гэр бүлээс нь тусгаарласан тохиолдолд хүүхдийг нэн тэргүүнд төрөл, садангийн болон бусад ойр дотны гэр бүлийн асрамжид байлгах асуудлыг анхаарч үзэх, хүүхдийг аль болох ах, эгч, дүүтэй нь хамт байлгах;

1.5.хүүхэдтэй хамааралтай аливаа шийдвэр гаргах, хүүхэд хамгааллын үйлчилгээний явцад хүүхдийн үзэл бодол, саналаа илэрхийлэх эрхийг хангах;

1.6.хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг үндэс, угсаа, нийгмийн гарал, байдал, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, эрхэлсэн ажил, албан тушаал, хөрөнгө чинээ, боловсрол, эрүүл мэнд, улс төрийн болон бусад үзэл бодлоос нь үл хамааран аливаа хэлбэрээр алагчлалгүйгээр үзүүлэх;

1.7.хүүхдийн нөхцөл байдал, онцлогийг хүлээн зөвшөөрөх, хүүхдийн нэр төрийг хүндэтгэх;

1.8.хүүхэд хамгааллын үйлчилгээний явц, үр дүнд хяналт тавих.

1.6 дугаар зүйл. Хүүхэд хамгаалал

1.Хүүхэд хамгааллын тогтолцоо нь салбар дундын болон хамтын ажиллагааны хэлбэрээр хэрэгжих бөгөөд дараах хэсгээс бүрдэнэ:

- 1.1.хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих олон нийтийн хандлага;
- 1.2.хүүхэд хамгааллын хууль тогтоомж;

- 1.3.мэргэжлийн удирдлага, зохион байгуулалт;
- 1.4.төсөв санхүүжилт, хуваарилалт;
- 1.5.хүүхэд хамгааллын хүний нөөцийн чадавхи;
- 1.6.хүүхэд хамгааллын үйлчилгээ.

2.Хүүхэд хамгааллыг дараах арга хэмжээгээр хэрэгжүүлнэ:

2.1.хүүхдийн гэр бүлд нь сууринсан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ;

2.2.хүүхдийг төрөл, садангийн болон бусад ойр дотны гэр бүлд байлгах;

- 2.3.хүүхдийг асралт гэр бүлд байлгах;
- 2.4.хүүхдийг асрамжийн үйлчилгээнд хамруулах;
- 2.5.хүүхдийг үрчлэх;
- 2.6.хүүхдийн аюулгүй байдлыг хангах;
- 2.7.нэг цэгийн үйлчилгээ;
- 2.8.эмнэлгийн туссламж, үйлчилгээ;
- 2.9.сэтгэл зүйн үйлчилгээ;
- 2.10.эрх зүйн туслалцаа туслалцаа;
- 2.11.урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа;
- 2.12.Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ.

3.Хүүхдийг үрчлэхтэй холбоотой харилцааг Гэр бүлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулиар зохицуулна.

4.Энэ зүйлийн 2.6-2.10 дахь хэсэгт хүүхэд хамгааллын арга хэжээг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар тухайллан зохицуулаагүйгээс бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

5.Хүүхэд хамгааллын талаар Монгол Улсын хууль тогтоомжид тусгайлан заасан тохиолдолд тухайн арга хэмжээ нь хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болно.

6.Хүүхэд бүр эрхээ зөрчигдсөн гэж үзвэл эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бусад өсгөн хүмүүжүүлж буй этгээддээ мэдэгдэхгүйгээр хүүхэд хамгааллын төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагад өргөдөл, гомдол гаргах болон мэдээлэл, зөвлөгөө авах эрхтэй. Энэ талаар хүүхдийн эцэг, эх, асран хамгаалах, харгалдан дэмжигчид мэдэгдэх нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй тохиолдолд хүүхэд хамгааллын байгууллага мэдээллийн нууцлалыг чандлан хадгална.

7.Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулах хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь Монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол орчуулагч, хэлмэрчийг гэрээ байгуулан ажиллуулна.

1.7 дугаар зүйл. Гомдол гаргах

1.Хүүхэд хамгааллын хэрэг (кэйс) нээснээс бусад хүүхэд хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд гаргасан шийдвэр, үйл ажиллагаа нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж байна гэж үзвэл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн улсын байцааг шүүхэд гомдол гаргах эрхтэй.

2.Шүүх энэ зүйлийн 2-т гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 дүгээр зүйл. Салбар дундын хамтын ажиллагаа

1.Төрийн бүх байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хүүхэд хамгааллын талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан орчныг бүрдүүлнэ.

2.Төрийн байгууллага, аж ахуйн нэгж нь хүүхдийн үүсгэл санаачилгын байгууллага, хүүхдийн элчийн үйл ажиллагааг дэмжиж, хүүхэд оролцсон арга хэмжээ, үйл ажиллагаанд хяналт тавина.

3.Энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд тухайн байгууллага, аж ахуйн нэгж нь хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд дэмжлэг үзүүлнэ.

2.2 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын байгууллагын тогтолцоо

1.Хүүхэд хамгааллын байгууллагын тогтолцоо нь хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд хамгааллын байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан, харьяа байгууллага, төвөөс бүрдэнэ.

2.Нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, гэр бүл, хүүхдийн тооноос хамаарч сум, хорооны нийгмийн ажилтны орон тоог хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

3.Хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу томилж, чөлөөлнө.

4.Аймаг, нийслэлийн хүүхэд хамгааллын байгууллагын даргыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

5.Дүүргийн хүүхэд хамгааллын байгууллагын даргыг нийслэлийн хүүхэд хамгааллын байгууллагын дарга, сум, хорооны нийгмийн ажилтныг аймаг, дүүргийн хүүхэд хамгааллын байгууллагын дарга тухайн сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцэн томилно.

2.3 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

1.Хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1.1.хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

1.2.хүүхэд хамгааллын бодлого, хөтөлбөр боловсруулах;

1.3.хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих;

1.4.хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал, үйлчилгээ үзүүлэх журмыг батлах;

1.5.шуурхай тусlamжийн үйлчилгээний аргачилсан заавар, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний нийтлэг журмыг батлах;

1.6.боловсролын сургалтын байгууллагад хүүхэд хамгааллын баг байгуулж ажиллуулах журмыг батлах;

1.7.хүүхэд асрах үйлчилгээ үзүүлэх журмыг батлах;

1.8.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журмыг батлах, магадлан итгэмжлэх;

1.9.хуульд заасан бусад бүрэн эрх.

2.4 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

1.Хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/ нь хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах, хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах үндсэн чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.

2.Төрийн захиргааны байгууллага нь хүүхэд хамгааллын чиглэлээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.хүүхдийн эрх, хамгаалын бодлогын хэрэгжилт, хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хамтарсан багийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах, үр дүнг үнэлэх;

2.2.хүүхдийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдал, хүүхэд хамгааллын үйлчилгээний үр дүнг Засгийн газар, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн өмнө хариуцан жил бүр тайлгнах;

2.3.хүүхэд хамгааллын үйлчилгээний үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлэх арга хэмжээг авах, мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээг үндэслэн тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжилтийг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах;

2.4.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхээр магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамтарч ажиллах, үйл ажиллагааг нь хянах, үнэлэх, дүгнэх;

2.5.хүүхдийг гэр бүл, нийгмийн бүх орчинд эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

2.7.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, нийгмийн ажилтныг чадавхижуулах сургалтын хөтөлбөр баталж хэрэгжүүлэх;

2.8.хүүхэд хамгааллын үйлчилгээний арга зүйг боловсруулах, хүүхэд хамгааллын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил зохион байгуулах;

2.9.хүүхэд хамгаалалд бүх шатны төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэн, гэр бүл, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжих;

2.10.шүүх, прокурор, хууль сахиулах байгууллага болон төрийн бусад байгууллага, хуулийн этгээдийн хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагчдыг сургаж, мэргэшүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

2.11.дараах мэдээлэл бүхий мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, ажиллуулах:

- 2.11.1.хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд;
- 2.11.2.үрчлэх боломжтой хүүхэд;
- 2.11.3.асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхэд;
- 2.11.4.хүүхэд үрчилж авсан иргэн болон үрчлэн авах хүсэлтэй иргэд;
- 2.11.5.асралт гэр бүл;
- 2.11.6.хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхэд;
- 2.11.7.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг хуулийн этгээд;
- 2.11.8.хүүхэд хамгаалалтай холбоотой шаардлагатай бусад мэдээлэл.

2.12.хуульд заасан бусад чиг үүрэг.

2.5 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын орон нутгийн байгууллагын чиг үүрэг

1.Аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд хамгааллын байгууллага /цаашид “хүүхэд хамгааллын орон нутгийн байгууллага” гэх/ нь тухайн нутаг дэвсгэрт хүүхдийн эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх зорилгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.хүүхдийн эсрэг хүчирхийлэл, эрсдэлт нөхцөл байгаа хүүхдийг илрүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн санд үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх;

1.2.бүртгэл, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар бүртгэл хөтөлж, төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

1.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, шаардлагатай тусlamж, үйлчилгээг үзүүлэх асуудлыг Хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой хамтран хэрэгжүүлэх;

1.4.сум, хорооны нийгмийн ажилтан, Хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

1.5.гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагчид хүүхэд өсгөх, хамгаалах талаар шаардлагатай зөвлөмж зөвлөгөө, тусlamж, дэмжлэг, үйлчилгээг үзүүлэх;

1.6.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг сайн дурын болон хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан сургалтад хамруулах ажлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулах;

1.7.хүүхэд хамгааллын талаархи мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлох;

1.8.харьялан орон нутагтаа төрийн байгууллага, хуулийн этгээд, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

1.9.гэр бүлээсээ дайжсан, эсхүл эцэг, эх, асран хамгаалагчийн халамж анхаарал, хараа хяналтаас гадуур байгаа хүүхдийг бүртгэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх ажлыг орон нутгийн Цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэх;

1.10.хуульд заасан бусад чиг үүрэг.

2.6 дугаар зүйл. Нийгмийн ажилтан

1.Нийгмийн ажилтан дараах эрхтэй:

1.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэдтэй нөхцөл байдлын талаар харилцан ярилцах, хуулиар хориглоогүй асуудлаар мэдээлэл цуглуулах;

1.2.хүүхэд хамгааллын асуудлаар хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, төрийн болон төрийн бус байгууллага, түүний удирдлага, иргэнд шаардлага тавих, зөвлөгөө өгөх;

1.3.хүүхдийн эрүүл мэнд, эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн талаар, түүнчлэн хүүхдийг эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх чиглэлээр хүүхдийг төлөөлөн зохих байгууллагад хүсэлт, өргөдөл гаргаж шийдвэрлүүлэх;

1.4.өөрийн амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл байдалд хүүхдэд эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх шаардлагатай болсон тохиолдолд цагдаагийн байгууллагын туслалцааг авах;

1.5.хуульд заасан бусад эрх.

2.Нийгмийн ажилтан дараах үүрэгтэй:

2.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг олж илрүүлэх, бүртгэх, мэдээлэл, зөвлөгөө өгөх;

2.2.хүчирхийлэлд өртсөн хүүхдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;

2.3.шаардлагатай эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, хөгжлийн болон бусад үйлчилгээнд хамруулах, холбон зуучлах үйлчилгээг зохион байгуулах;

2.4.хүүхэд, түүний гэр бүлд шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах;

2.5.хүүхэд хамгааллын хэрэг (кэйс)-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд орон нутгийн байгууллага, иргэнийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах;

2.6.хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах;

2.7.хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хууль тогтоомж зөрчсөн талаар хүүхдийн эрхийн улсын байцаагч болон эрх бүхий байгууллагад заавал мэдээлэх, шалгуулах;

2.8.мэргэжлийн ёс зүй, эрх, үүрэгт нь болон үйлчилгүүлэгчид харш үйлдэл гүйцэтгэхээс татгалзах.

2.9.хуульд заасан бусад үүрэг.

3.Нийгмийн ажилтанд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх эрх, мэргэжлийн зэрэг олгох, цуцлах асуудлыг хүүхэд хамгааллын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

4.Нийгмийн ажилтан ёс зүйн дүрэмтэй байна. Нийгмийн ажилтны ёс зүйн дүрмийг мэргэжлийн холбоодтой зөвшилцөн хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.7 дугаар зүйл. Хүүхдийн эрхийн улсын байцаагч

1.Хүүхдийн эрхийн улсын байцаагч хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1.1.хүүхдийн эрхийн зөрчлийн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээллийг нийгмийн ажилтанд, орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллагад мэдэгдэх, зөрчлийн шинжтэй үйлдлийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалган шийдвэрлэх;

1.2.тухайн өргөдөл, гомдол, мэдээллийг шалгах явцад хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул учирсан, эсхүл уг нөхцөл бүрдсэн, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч үйлдсэн, хүүхдийг тухайн орчинд үлдээх боломжгүй нөхцөл үүссэн бол яаралтай түр тусгаарлах арга хэмжээг эрх бүхий албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлэх;

1.3.хүүхэд хамгааллын үйлчилгээний явцад болон гэр бүл, нийгмийн орчинд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавих, гарсан зөрчил, дутагтлыг албан шаардлага, зөлөмж бичиж арилгуулах арга хэмжээ авах;

1.4.хүүхдийн эрхийг зөрчсөн үйл ажиллагаа явуулсан албан хаагч, ажилтанд сахилгын хариуцлага тооцох асуудлыг эрх бүхий этгээдэд тавьж шийдвэрлүүлэх;

1.5.түр хамгаалах байр, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдийн байр, үйл ажиллагаа явуулж байгаа газар саадгүй нэвтрэх, холбогдох баримт бичиг, мэдээлэлтэй танилцах;

1.6.хуульд заасан бусад бүрэн эрх.

2.8 дугаар зүйл. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо

1.Аймаг, дүүргийн Засаг дарга нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо (цаашид “Хороо” гэх)-г байгуулна.

2.Хороо нь тухайн орон нутгийн хамгааллын; цагдаагийн; шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын; прокурорын нэгжийн; шүүхийн тамгын газар, хэлтсийн удирдах албан тушаалтнуудаас бүрдэнэ.

3.Хороо нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн, зөрчигдсөн тохиолдолд тухайн асуудлыг хамтын журмаар шийдвэр гаргаж дараах үйлчилгээг үзүүлнэ:

3.1.гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн, хүмүүжлийн чанартай арга хэмжээ авагдсан хүүхдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авах, шүүхээс хүүхдэд даалгасан үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

3.2.сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

3.3.гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар санал гаргах;

3.4.гэмт, хэрэг зөрчилд холбогдсон, эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээсэн хүүхдийг зөв зохистой хүмүүжил олгох сургалт, хөтөлбөрт хамруулах;

3.5.эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох;

3.6.хорт зуршлаас ангижрах эмчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх, ажил, сургууль, мэргэжил олгох сургалтад хамруулах;

3.7.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах.

4.Хорооны шийдвэр нь тогтоол, зөвлөмж хэлбэртэй байх бөгөөд уг шийдвэрийн хэрэгжилтэнд Ажлын албаар дамжуулан эсхүл Хорооны гишүүд биечлэн хяналт тавина.

5.Хороо нь гаргасан шийдвэрийг хэрэгжүүлээгүй эсхүл хэрэгжүүлэхэд саад учруулсан төрийн албан хаагчид сахилгын хариуцлага тооцуулахаар томилсон эрх бүхийн этгээдэд санал хүргүүлнэ.

6.Хорооны гаргасан шийдвэр, үзүүлсэн тусламж үйлчилгээний мэдээллийн санг Ажлын алба бурдуулж, үндэсний хэмжээнд мэдээллийн сангийн үйл ажиллагааг төрийн захиргааны байгууллага удирлагаар хангаж, хяналт тавина.

7.Хорооны Ажлын албаны үүргийг орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага хэрэгжүүлнэ.

8.Хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хууль зүйн болон хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

2.9 дүгээр зүйл. Хамтарсан баг

1.Хамтарсан баг нь тухайн орон нутгийн хүүхэд хамгааллын байгуулага, нийгмийн ажилтантай хамтран ажиллана.

2.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуульд заасны дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээний тодорхой чиглэлээр мэргэшсэн хамтарсан багийг байгуулж болно.

3.Хамтарсан баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.хүүхдийг хамгаалах, хүүдийн эсрэг хүчирхийлэлтэй эвлэрэшгүй байх хандлага, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

3.2.хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;

3.3.хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээний хугацаатай хөтөлбөр, төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх;

3.4.нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн татан оролцуулах, иргэдийн хяналтыг бий болгох;

3.5.хүүхэд хамгаалах үйлчилгээний төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх;

3.6.хүүхдийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуучлах;

4.Нийгмийн ажилтан Хамтарсан багийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэнэ.

2.10 дугаар зүйл. Хүүхэд хамгаалалд төрийн бус байгууллагын оролцоо

1.Хүүхэд хамгааллын үйлчилгээг тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

2.Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх, цуцлах эсэх асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулж ажиллуулна.

3.Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагыг чадавхижуулах, сургалт зохион байгуулах ажлыг төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

4.Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явууллаг төрийн бус байгууллагын мэдээллийн санг төрийн захиргааны байгууллага бүртгэж, хөтөлнө.

5.Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллагын үйл ажиллагаа нь Монгол Улсын хүүхэд хамгааллын бодлого, хүүхэд хамгааллын үйлчилгээний шаардлагад нийцсэн байна.

6.Энэ зүйлийн 5-д заасан байгууллага нь Монгол Улсад хэрэгжүүлэх хүүхэд хамгааллын төсөл, хөтөлбөрөө хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

2.11 дүгээр зүйл. Хороо, Хамтарсан багийн харьяалал, хамтын ажиллагаа

1.Хороо, Хамтарсан баг нь хүүхдийн оршин суугаа хаягийн харьяаллын дагуу хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлнэ.

2.Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх явцад хүүхдийн ошин суугаа хаяг өөрчлөгдсөн тохиолдолд тухайн өөрчлөгдсөн газрын Хороо, Хамтарсан баг хүүхэд хамгааллын үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлнэ.

3.Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд харьяаллын маргаан гарсан эсхүл хүүхэд оршин суугаа хаяг нь тодорхойгүй байгаа тохиолдолд төрийн

захиргааны байгууллага хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх харьяаллыг тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГЭР БҮЛ, НИЙГМИЙН ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

3.1 дүгээр зүйл. Гэр бүл дэх хүүхэд хамгаалал

1. Эцэг, эх нь хүүхдийг бие бялдар, сэтгэл санааны хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хараа, хяналтгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн дарамтаас хамгаалах үүрэгтэй. Эцэг, эх энэ хуульд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээ авах эрхтэй.

2. Эцэг, эх нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, асран хамгаалахдаа хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бие махбодийн шийтгэлээс ангид хүмүүжлийн эерэг арга хэрэглэнэ.

3. Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, асран хамгаалахад шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл, тусламж үйлчилгээг хүүхэд хамгааллын төрийн болон орон нутгийн байгууллагад хандан авч болно.

4. Эцэг, эхчүүд энэ хуулийн дагуу авсан арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

5. Эцэг, эх энэ хуулийн 1.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн дагуу авсан бүх арга хэмжээ, үйлчилгээний талаар мэдээлэл авах, зөвлөгөө авах эрхтэй. Эцэг, эх нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг цуцлуулах, өөрчлүүлэх хүсэлтийг гаргаж болно.

6. Энэ зүйл нь хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нэгэн адил үйлчилнэ.

3.2 дугаар зүйл. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал

1. Боловсролын сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг тухайн байгууллагадаа хөтөлбөр, төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллана.

2. Боловсролын сургалтын байгууллага сургач бүрийг тухайн орчинд сэтгэл зүйн болон гэмт хэрэг, зөрчил, хорт зуршил, дээрэлхэлт, хүчирхийлэлд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

2.1. боловсролын сургалтын байгууллагын удирдах албан тушаалтан хүүхэд хамгааллын багийг байгуулж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах;

2.2. хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулж болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээнд хүүхдийг оролцуулахгүй байх;

2.3. дээрэлхэх үйлдэл, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, зүй бус хандлага, гэмт хэрэг, хорт зуршилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг авах.

3.Бүх бага, дунд сургууль дээрэлхэх үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, арилгахад чиглэсэн бодлоготой байх бөгөөд сургуулийн захирал, сургуулийн нийгмийн ажилтан уг бодлогын хэрэгжилт, хяналтыг хариуцна.

4.Сургуулийн захиргаа, сургач, эцэг эх, сайн дурын ажилтан хэн боловч дээрэлхэх үйлдлийн гэрч болсон, эсхүл ийм үйлдлийн талаар мэдсэн, таамагласан тохиолдолд сургуулийн захирал эсхүл сургуулийн нийгмийн ажилтанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

5.Энэ зүйлийн 4-т заасан мэдээллийг хүлээн авмагц сургуулийн захирал, сургуулийн нийгмийн ажилтан уг мэдээллийн дагуу нэн даруй шалгалт явуулна. Шалгалтаар дээрэлхэх үйлдэл гарсан нь тогтоогдвол сургуулийн захирал, эсхүл сургуулийн нийгмийн ажилтан дараах арга хэмжээг авна:

5.1.дээрэлхэх үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй байвал цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

5.2.дээрэлхэх үйлдэл гаргасан сургачийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид мэдэгдэх;

5.3.хохирогч сургачийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид мэдэгдэх;

5.4.дээрэлхэх үйлдлийн талаар мэдээлсэн сургачийн мэдээллийн нууцыг хадгалах, цаашид дээрэлхэх үйлдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

6.Нэгээс олон сургуулийн сургачид дээрэлхэх үйлдлийг гарсан бол уг үйлдлийг анх мэдсэн сургууль бусад сургуулийн захиргаанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд тухайн сургуулийн захиргаа энэ зүйлийн 5 дахь хэсэг заасан арга хэмжээг нэгэн адил авах үүрэгтэй.

Тайлбар: -"дээрэлхэх үйлдэл" гэж нэг буюу хэд хэдэн сургач өөр нэг буюу хэд хэдэн сургачийг санаатайгаар, удаа дараа бие махбодь, оюун ухаан, сэтгэл санааны хувьд гэмтээх, зовоох, айлган сүрдүүлэх, заналхийлэх зорилготой түрэмгий зан үйлээ биеэр, амаар, цахим хэлбэрээр илэрхийлэхийг;

3.3 дугаар зүйл. Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал

1. Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн терийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц бүх төрлийн дуу авиа, дүрс, үйл явдал оруулсан контент, бүтээлээс хамгаална.

2.Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөргөөр нөлөөлөх бүх төрлийн дуу авиа, дүрс, үйл явдал оруулсан контент, бүтээлээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж цахим

орчин, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

3.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн хүүхдэд зориулсан бүх төрлийн дуу авиа, дүрс, үйл явдал оруулсан контент, бүтээл нь хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй гэж үзсэн иргэн, хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч, хүүхдийн эрхийн ажилтан энэ тухай гомдол, мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд гаргаж шийдвэрлүүлнэ.

4.Сонин хэвлэл, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ, цахим орчин ашиглаж, хүүхдийн хувийн нууцад халдаж дуу, дуу-дүрсний, дүрсний бичвэр, гэрэл зураг тараасан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж мэдээлсэн, олны өмнө гутаасан ажилтан, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5. 16 насанд хүрээгүй хүүхэд бусад хүүхдийнхээ эсрэг хийсэн энэ зүйлийн 4-т заасан үйлдлээс үүсэх хохирол, хор уршгийг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуульд заасны дагуу хариуцна.

6.Үүрэн холбооны, интернетийн болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь хүүхдэд зориулсан тусгай багцын үйлчилгээтэй байх бөгөөд үйлчилгээний гэрээ байгуулахдаа тухайн этгээдийн асран хамгаалалд 18 нас хүрээгүй хүүхэд байгаа эсэхийг заавал асууж, насанд хүрэгчдэд зориулсан тусгай сувгийн үйлчилгээ эсхүл шүүлтүүртэй интернетийн үйлчилгээг хэрэглэх эсэхийг тохиролцно.

7.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл нь цахим орчин болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хүрээнд хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах орон тооны бус дэд зөвлөл байгуулж, зөвлөлийн бүрэлдэхүүнд иргэд, интернетийн болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн төлөөлөлтэйгээр хүүхэд хамгааллын салбар дундын бодлогыг хэрэгжүүлж, хяналт тавина.

8.Үүрэн холбооны болон интернетийн үйлчилгээ эрхлэгч нь цахим орчинд хүүхдийн эсрэг агуулгатай, хууль зөрчсөн контентийг өөрийн сүлжээнд даруй хязгаарлах үүрэг хүлээнэ.

9.Иргэн, албан хаагч бүр цахим орчинд хүүхдийн эрх зөрчигдсөн, дарамт хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн байж болзошгүй тохиолдлыг тухайн орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага, Хамтарсан баг болон цагдаагийн байгууллагад мэдээлнэ.

3.4 дүгээр зүйл. Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал

1.Худалдаа, үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал цуглаан, замын хөдөлгөөн, хүүхэд оролцсон шалгалт, уралдаан тэмцээний үед хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үүргийг зохион байгуулагч болон оролцогч талууд ханган ажиллана.

2.Энэ зүйлийн 1-д заасан арга хэмжээ, үйлчилгээг зохион байгуулагч хууль, захиргааны хэм хэмжээний акт, гэрээ хэлцлээр хүлээсэн үүргээ

биелүүлээгүйн улмаас хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учрах нөхцөл бүрдсэн, эсхүл хохирол учирсан бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

3.Энэ зүйлийн 1-д заасан арга хэмжээ, үйлчилгээний үед хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзсэн хувь хүн, хуулийн этгээд тухайн орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан, эсхүл энэ хуулийн 5.11 дүгээр зүйлийн 6-д заасан утсанд заавал мэдээлнэ.

4.Олон нийтийн үйлчилгээ, арга хэмжээний үед хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулна.

3.5 дугаар зүйл. Соёл, спортын үйл ажиллагаан дахь хүүхэд хамгаалал

1.Хүүхдийг соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхгүй орчинд оролцуулна.

2.Хүүхдийг соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд оролцуулахдаа хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, хоцрогдлыг арилгах арга хэмжээг авна.

3.Хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, хоцрогдлыг арилгах арга хэмжээг эцэг, эх, асран хамгаалагч, арга хэмжээнд оролцуулсан этгээд хамтран, сургалтын хөтөлбөр, агуулгын хүрээнд болон төрийн захиргааны байгууллагаас улс, бүс, орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа арга хэмжээнд оролцсон бол сургуулийн удирдлага тус тус зохион байгуулна.

4.Улсын баяр наадам, шигшмэл, бүсийн уралдаан болон бусад аливаа хэлбэрийн хурдан морины уралдааны бэлтгэл үе шат /үсэргээ, сунгаа/, уралдаанд уяач нь уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах хүрээнд дараах арга хэмжээг авна:

4.1.уралдаанч хүүхдийн сурч боловсрох эрхийг зөрчихгүй байх, боловсролын үйлчилгээ авах эрхийг тасалдуулахгүй байх;

4.2.уралдаанч хүүхдийн бие махбодид гэмтэл учирсан, амь нас, эрүүл мэндэд эрсдэл учрах нөхцөл байдал бий болсон үед хүүхдийг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэн даруй хамруулах, үүнтэй холбоотой гарах зардлыг хариуцах;

4.3.уралдаанч хүүхдийг гэнэтийн ослын даатгалд даатгуулсан байх;

4.4.уралдаанч хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулж нас, жин, өндрийг тусгайлан тэмдэглэж дүгнэлт гаргуулсан байх;

4.5.уралдаанч хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчтай хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ажлын хөлс, бай шагналыг тусгасан гэрээ байгуулсан байх;

4.6.хурдан морины хэрэгслийг хүүхэд болон морины биед тохирсон байхаар сонгох, түүний бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хангах;

4.7.уралдаанч хүүхдэд стандартын шаардлага хангасан хамгаалалтын хувцас өмсүүлэх;

4.8.уралдаанч хүүхдийг нэг өдөр 2-оос дээш насын мор унуулахгүй байх. Энэ заалт нь уралдааны бэлтгэл үе шатанд хамаarahгүй.

5.Уяач нь энэ зүйлийн 4-т заасан хурдан морины уралдааны бэлтгэл үе шат эхлэхээс өмнө морь унах уралдаанч хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч болон хүүхдээс бичгээр зөвшөөрөл авч, нийгмийн ажилтанд бүртгүүлнэ. Нийгмийн ажилтан хүүхдэтэй ганцаарчлан уулзаж хүүхдээс морь унаж уралдах хүсэлтэй байгаа эсэхийг тодруулж баталгаажуулах ба хүүхэд морь унаж уралдах хүсэлгүй байгаа тохиолдолд хурдан морины уралдаан зохион байгуулах хороо, комисст энэ талаар мэдэгдэж уралдаанд оролцуулахгүй байх арга хэмжээг авна.

6.Хурдан морины уралдааны бэлтгэл үе шатанд болон уралдаан эхлэхээс өмнө уралдаанч хүүхдийг өөрчлөх тохиолдолд энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан журам нэгэн адил үйлчилнэ.

7.Уяачид энэ зүйлийн 5, 6-д заасны дагуу бүртгүүлсэн хүүхдээс өөр хүүхдээр морь унуулахыг хориглоно.

8.Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмыг соёлын болон хүүхэд хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж, мөрдүүлнэ.

3.6 дугаар зүйл. Гамшиг, гамшигийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал

1.Хүүхэд ямар ч хориглолт хязгаарлалтын үед хүүхэд хамгааллын үйлчилгээ авах эрхтэй.

2.Цар тахал, гамшиг, онцгой байдлын нөхцөлд хүүхэд хамгааллын үйлчилгээг боломжит бүхий л хэлбэрээр хүргэх бөгөөд энэ хуульд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээг зогсоохыг хориглоно.

3.Цар тахал, гамшиг, онцгой байдлын нөхцөлд хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэхэд цахим платформ, цахим гарын үсэг, зөвшөөрөл ашиглаж болох ба төрийн бүхий л байгууллага, албан тушаалтууд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4.Цар тахал, гамшиг, онцгой байдлын үед хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг цаг алдалгүй шуурхай үзүүлэх үйл ажиллагааг хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, төрийн бус байгууллага, сайн дурын оролцоотойгоор зохион байгуулна.

5.Гамшигаас хамгаалах болон гамшигийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны бүхий л шатанд баримтлах Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд

хамгааллын үйлчилгээний стандартыг Стандартын асуудал эрхэлсэн байгууллага батална.

-**Тайлбар:** Энэ зүйлд заасан төрийн байгууллага гэдэгт хүүхэд хамгааллын, эрүүл мэндийн, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, цагдаа, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, Хүний эрхийн үндэсний комисс хамаарна.

3.7 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн төлөөллийг хэрэгжүүлэх

1.Өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгч нь хуульд заасан шийдвэр гаргаж, үйл ажиллагаа явуулахдаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн эрх зөрчигдсөн, амьдрах хэвийн орчин алдагдсан бусад туслалцаа дэмжлэг шаардлагатай хүүхдийн талаар олж мэдсэн тохиолдолд тухайн орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага, нийгмийн ажилтанд заавал мэдэгдэж, тухайн хэргийг шийдвэрлэж дуусах хүртэл хугацаанд хамтран ажиллана.

2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л ѿ шатанд хүүхдийг нас сэтгэхүйн онцлогт тохирсон мэдээллээр хангаж, өөртөө холбоотой шийдвэрт үг хэлэх, үзэл бодол, саналаа илэрхийлэх боломжоор хангана.

3.Нийгмийн ажилтан нь хуульд заасан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрх зөрчигдсөн талаар эсхүл хүүхдийн амьдарч, сурч байгаа орчин, бусад нөхцөл байдлын талаар шинжээчээр оролцож дүгнэлт гаргана. Нийгмийн ажилтан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчээр оролцсон тохиолдолд тухайн томилсон байгууллага зардлыг хариуцан гаргана.

4.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрхийн эсрэг ашиг сонирхолтой гэж үзэх нөхцөл байдал тогтоогдвол нийгмийн ажилтан эсхүл хүүхдийн эрхийн ажилтан хүүхдийн эрхийн төлөөллийг хэрэгжүүлнэ.

5.Хүүхдийн эрхийн улсын байцаагч хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор Гэр бүлийн тухай хуульд заасан үндэслэлээр эцэг, эх байх эрхийг хязгаарлуулах, хасуулах, үрчлэлтийг хүчингүйд тооцуулах тухай хүсэлтийг шүүхэд гаргаж шийдвэрлүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХЭРЭГ (КЭЙС)-ИЙН МЕНЕЖМЕНТ

4.1 дугаар зүйл. Олон нийтийн мэдэгдэх үүрэг

1.Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн хэн боловч энэ талаар тухайн орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага, эсхүл сум, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэх үүрэгтэй.

4.2 дугаар зүйл. Хүүхэдтэй талаар этгээдийн мэдэгдэх үүрэг

1.Хүүхдэд хамаатай асуудалд эрхэлж буй ажил, албан үүргээрээ холбогдсон этгээд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд энэ хуулийн 4.1 дүгээр зүйлд заасны дагуу мэдэгдэх үүрэгтэй.

2.Боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч, менежер, багш, нийгмийн ажилтан, түүнчлэн эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, лам, санваартан, хүүхэд асрагч, гэрийн үйлчлэгч, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг хуулийн этгээдийн ажилтан, нийгмийн халамжийн байгууллагын албан хаагч, нийгмийн ажил, үйлчилгээ эрхэлдэг хүмүүс ажил, албан үүргээ гүйцэтгэх явцдаа хүүхдийн зан байдал, хүмүүжил, нөхцөл байдалд хяналт тавих, хүүхэд эрсдэлт нөхцөлд орсон бол энэ талаар тухайн орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэх онцгой үүрэгтэй.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдэгдэх үүрэг нь тухайн этгээдийн баримтлах ёс зүйн дүрэм, мэргэжлийн нууц, хууль, гэрээ, хэлцлээр хүлээсэн үүргийн зохицуулалтаас давуу үйлчилнэ.

4.3 дугаар зүйл. Хүүхдийн талаар мэдэгдэх, хүүхдээс мэдүүлэг авах цагдаагийн албан хаагчийн үүрэг

1.Цагдаагийн албан хаагч эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд энэ хуулийн 4.1 дүгээр зүйлд заасны дагуу мэдэгдэх үүрэгтэй.

2.Хүүхэд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон эсхүл гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогч болсон байж болзошгүй талаарх гомдол, мэдээллийг хүлээн авсан цагдаагийн албан хаагч энэ талаар тухайн харьяа Хороонд 24 цагийн дотор мэдэгдэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцох боломжоор хангана.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан мэдээллийг хүлээн авсан Ххороо нь хүүхдийн эрхэд харшлахгүй гэж үзвэл энэ талаар хүүхдийн эцэг, эхэд нь мэдэгдэнэ.

4.Хорооноос томилогдсон төлөөлөгч нь гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхдээс мэдүүлэг, тайлбар авах ажиллагаанд байлцах боломжоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу хангагдана. Энэ заалт нь гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, гэрч болсон хүүхдэд нэгэн адил хамаарна.

5.Энэ зүйл нь гэмт хэрэг, зөрчилд холбогдсон эсхүл гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогч хүүхдээс шүүхийн шатанд мэдүүлэг авах ажиллагаанд нэгэн адил үйлчилнэ.

4.4 дугаар зүйл. Мэдээлэл өгсөн этгээдийг нууцлах

1. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэл өгсөн этгээд нь өөрийнхөө тухай мэдээллийг бусад этгээдэд задруулахгүй байх хүсэлт гаргасан тохиолдолд орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага хүсэлтийг хүлээн авахгүй байх онцгой шалтгаан байхгүйгээс бусад тохиолдолд түүний хүсэлтийг хүлээж авч мэдээллийн нууцлалыг хадгална. Энэ заалт энэ хуулийн 4.2, 4.3 дугаар зүйлд заасан этгээдэд хамаарахгүй.

4.5 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын хэрэг (кэйс) нээх

1. Энэ хуулийн 4.1, 4.2, 4.3 дугаар зүйлд заасны дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэл хүлээн авсан, эсхүл өөрөө илрүүлсэн, хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан тохиолдолд орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага, нийгмийн ажилтан нь мэдээллийг Хамтарсан баг руу шилжүүлнэ. Хамтарсан баг мэээллийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хүүхэд хамгааллын хэрэг (кэйс) нээх эсэхийг шийдвэрлэнэ.

2. Хамтарсан баг хүүхэд хамгааллын хэрэг (кэйс) нээх шийдвэр гаргаснаас хойш 7 хоногийн дотор тухайн хүүхдийн эцэг, эхэд энэ тухай мэдэгдэнэ. Хэрэв хүүхэд хамгааллын хэргийг шалгах ажиллагаанд саад учруулж болзошгүй гэж үзвэл эцэг, эхэд нь өгөх мэдэгдлийг хойшлуулж болно.

4.6 дугаар зийл. Нөхцөл байдлын үнэлгээ хийх

1. Хамтарсан баг хүүхдийн нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулж, хүүхэд хамгааллын ямар үйлчилгээг хүргэх шаардлагатайг тодорхойлох зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.

2. Нөхцөл байдлын үнэлгээнд хүүхдийн бие махбодь, сэтгэл санаа болон гэр бүлийн нөхцөл байдал, хүүхдийн эцэг, эхтэйгээ харилцах харилцаа, хүүхдийн сургуулийн орчин, нөхцөл байдал, хүүхдийн зан байдал, хүмүүжил, эрүүл мэнд зэрэг хүүхэдтэй холбоотой бүхий л нөхцөл байдлыг үнэлж, тусгана.

3. Нөхцөл байдлын үнэлгээг хийхэд шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжилтний туслалцааг авч болно.

4. Нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

5. Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн Хамтарсан багийн гишүүнд нэмэгдэл урамшуулал олгох бөгөөд уг журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

4.7 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын хэрэг (кэйс)-ийн төлөвлөгөө

1. Хамтарсан баг нөхцөл байдлын үнэлгээг хангалттай гүйцэтгэсэн гэж үзсэн тохиолдолд хүүхдийн нөхцөл байдлыг цаашид хэрхэн сайжруулах болон

хүүхэд хамгааллын шаардлагатай үйлчилгээний талаарх саналыг тусгасан тайлан гаргана.

2. Нэхцөл байдлын үнэлгээний үр дүнд хүүхдэд энэ хуульд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх шаардлагатай гэж дүгнэсэн тохиолдолд Хамтарсан баг хүүхдийн эцэг, эх, боломжтой бол хүүхэд (14-өөс дээш насны)-тэй зөвшилцөн хүүхэд хамгааллын хэрэг (кэйс)-ийн төлөвлөгөөг бичгээр гаргана. Эцэг, эх, хүүхэдтэй зөвшилцөлд хүрэх боломжгүй тохиолдолд Хамтарсан баг төлөвлөгөөг дангаар гаргаж хэрэгжүүлнэ.

3. Төлөвлөгөөг тодорхой хугацаанд хэрэгжүүлэхээр гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд хугацаанд өөрчлөлт оруулж болно.

4. Хамтарсан баг төлөвлөгөөг боловсруулах болон хэрэгжүүлэхдээ өөр бусад этгээдтэй хамтарч ажиллах шаардлагатай эсэхийг тодорхойлно.

5. Алслагдмал газар, засаг захиргааны нэгж өсхүл төрийн үйлчилгээ үзүүлэх боломжгүй тодорхой хэсэгт хүүхэд хамгааллын үйлчилгээг явуулын хэлбэрээр хүргэх асуудлыг төлөвлөгөөнд тусгана.

6. Төлөвлөгөөний хугацаа дууссаны дараа Хамтарсан баг хүүхэд хамгааллын хэрэг (кэйс)-ийг хаах шийдвэр гаргавал хүүхдийн эцэг, эх тухайн шийдвэрийг эс зөвшөөрч тухайн орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллагад гомдол гаргаж болно.

4.8. дугаар зүйл. Хүүхэд хамгааллын хэрэг (кэйс)-ийн бүртгэл

1. Нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын хэрэг (кэйс)-ийг хөтөлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд хийгдсэн бүх үйл ажиллагааг холбогдох маягт, зааврын дагуу заасан хугацаанд бүртгэж, баримтжуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

5.1 дүгээр зүйл. Гэр бүлд сууринсан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ

1. Хамтарсан баг энэ хуулийн 4.7 дугаар зүйлд заасан төлөвлөгөөний дагуу гэр бүлд нь сууринсан дараах хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх буюу холбон зуучлах ажлыг хэрэгжүүлнэ:

1.1. эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхдийг асрах, өсгөж бойжуулах болон боловсролын асуудлаар хүмүүжил, сэтгэл зүй, хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх;

1.2. эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг нийгэмшүүлэх, эргэн хэвийн амьдралд ороход нь туслах зорилгоор нөхөн сэргээх төвд хамруулах;

1.3.хүүхдийн онцлог, хөгжлийн түвшинд тохируулан зөвлөгөө, мэдээлэл өгөх;

1.4.нийгмийн халамжийн үйлчилгээнд хэрхэн хамрагдах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зөвлөгөө, мэдээлэл өгөх;

1.5.амьжиргааны нөхцөлийг сайжруулах зорилгоор тусламж үзүүлэх;

1.6.хүүхэд, эцэг, эхийн харилцааг сайжруулах, харилцааны зөрчил, хямралыг шийдвэрлэх нийгмийн ажил явуулах, сургалтанд хамруулах;

1.7.архи, согтууруулах ундаа, мансууруулах ба сэтгэцэд нөлөөлөх эм, бодисоос эцэг эх, асран хамгаалагчтай ажиллах тусгай хөтөлбөр ба үйлчилгээнд хамруулах;

1.8.гэр бүлийн хүчирхийллийн харилцаатай эцэг эх, асран хамгаалагчийг зан үйлд нөлөөлөх албадан болон сайн дурын хөтөлбөрт хамруулах;

1.9.хүүхдийн чадвар, сонирхлыг судалж, зохих боловсролын байгууллагад шилжүүлэх;

1.10.Хөдөлмөрийн тухай хуульд заасан нөхцөл, шаардлагын хүрээнд хүүхдийг ажилтай болоход нь дэмжлэг үзүүлэх;

1.11.хүүхдийг чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөхөд тохиромжтой үйл ажиллагаанд хамруулах;

1.12.хүүхэд үрчилж авсан эцэг, эхэд эцэг, эхийн үүрэг, хариуцлага хүлээх, үрчлэх үйл ажиллагааг дуусгавар болгох, үрчлэлтийг цуцалсан тохиолдолд хүүхдийн эрхийг хамгаалах зэрэг асуудалд туслалцаа үзүүлэх.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт хүүхэд хамгааллын үйлчилгээг хослуулан үзүүлж болно.

5.2 дугаар зүйл. Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлан хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх

1.Энэ хуулийн 5.5 дугаар зүйлд хүүхэд хамгааллын үйлчилгээ үр дүнд хүрээгүй эсхүл эсхүл хүүхдийг гэр бүлд байлгах нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшилна гэж Хамтарсан баг үзсэн тохиолдолд тухайн орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллагад хүүхдийг дараах гэр бүлээс нь тусгаарлан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх саналыг хүргүүлнэ.

2.Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна:

1.1.төрөл, садан, бусад ойр дотны гэр бүлд байлгах;

1.2.асралт гэр бүлд байлгах;

1.3.төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах.

2.Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлан хүүхэд хамгааллын үйлчилгээ авах хүсэлтийг хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тухайн орон нутгийнхаа хүүхэд хамгааллын байгууллагад гаргаж болно.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт арга хэмжээг авч асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоох эсэхийг тухайн орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллагын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ. Засаг даргын шийдвэр гарах хүртэлх хугацаанд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын үүднээс хүүхдийн оршин суугаа хаяг дах орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага нь хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлах арга хэмжээг урьдчилан авч болно.

4.Сум, дүүргийн Засаг дарга хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлах арга хэмжээ авах эсэхийг шийдвэрлэхдээ уг ажиллагаанд хүсэлт гаргасан тал, хүүхэд хамгааллын байгууллагын төлөөлөл болон хүүхдийг оролцуулна.

5.Нийгмийн ажилтан энэ хуулийн 5.7 дугаар зүйлийн 1.5, 1.6, 1.7-д заасан үндэслэлээр гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхдийг боломжтой тохиолдол бүрд гэр бүлд нь эргэн нэгтгэх үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавина.

5.3 дугаар зүйл. Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлах үндэслэл

1.Хүүхдийг дараах үндэслэлээр гэр бүлээс нь тусгаарлах арга хэмжээг авна:

1.1.эцэг, эх нь нас барсан;
1.2.шүүхээс эцэг, эхийг хоёуланг нь нас барсан, сураггүй алга болсонд тооцсон;

1.3.эцэг, эх нь хоёул шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүйд тооцогдсон;

1.4.эцэг, эх байх эрхийг нь хассан, хязгаарласан;
1.5.эцэг, эх нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүүхдийг асран халамжлах үүргээ удаа дараа биелүүлээгүй;

1.6.эцэг, эх нь хүүхдээ асран халамжлах чадваргүй болсон;
1.7.эцэг, эх нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн болон хүүхдийг үл хайхарсны улмаас хүүхдийн бие махбодь, оюун ухаан, сэтгэл санаа, ёс суртахууны хөгжилд эрсдэл учирсан.

5.4 дүгээр зүйл. Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлах журам

1.Хүүхдийг төрөл, садангийн болон ойр дотны бусад гэр бүлд байлгах тохиолдолд тэдний зөвшөөрлийг урьдчилан авч, тухайн гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээ хийнэ.

2.Хүүхдийг асралт гэр бүлд байрлуулах тохиолдолд тухайн гэр бүл нь энэ хууль болон холбодох захиргааны хэм хэмжээний актад заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, асралт гэр бүлтэй гэрээ байгуулсны үндсэн дээр байрлуулна.

3.Сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрх, ашиг сонирхолд нийцсэн гэж үзвэл хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлан хамгаалахаар урьд авсан арга хэмжээг хүчингүй болгох, эсхүл өөрчилж болно.

4.Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарласан арга хэмжээг өөрчилсөн тохиолдолд энэ зүйлд заасан журам нэгэн адил үйлчилнэ.

5.5 дугаар зүйл. Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлах арга хэмжээг цуцлах

1.Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарласан арга хэмжээг дараах үндэслэлээр цуцална:

- 1.1.гэрээ цуцлагдсан;
- 1.2.гэр бүлээс нь тусгаарлах арга хэмжээний хугацаа дууссан;
- 1.3.гэрээний талууд харилцан тохиролцсон;
- 1.4.хүүхэд үрчлэгдсэн;
- 1.5.хүүхэд 18 насанд хүрсэн бөгөөд үргэлжлүүлэн 21 нас хүртэл хүүхэд хамгааллын үйлчилгээ авахыг зөвшөөрөөгүй;
- 1.6.энэ хуулийн 5.5 дугаар зүйлд заасан үндэслэл хүчингүй болсон;
- 1.7.асралт гэр бүлийн эхнэр, нөхөр нас барсан;
- 1.8.гэр бүлээс нь тусгаарлах арга хэмжээг өөрчилсөн.

5.6 дугаар зүйл. Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлах арга хэмжээг цуцлах журам

1.Нийгмийн ажилтан, асралт гэр бүл, хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр сум, дүүргийн Засаг даргаг хүүхдийг гэр бүлээс нь тусгаарласан арга хэмжээг цуцалж болно.

2.Засаг даргын шийдвэр гарах хүртэлх хугацаанд орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага хүүхдийн цаашдын асрамж, хүмүүжил эсхүл хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилшоор хүүхдийг гэр бүлээс тусгаарласан арга хэмжээг цуцалж, хүүхдийг хамгаалах өөр арга хэмжээг түр авч болно.

3.Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарласан арга хэмжээг цуцалсан сум, дүүргийн Засаг даргын шийдвэрийг орон нутгийн хүүхдийн байгууллага гүйцэтгэнэ.

5.7 дугаар зүйл. Хүүхдийг асралт гэр бүлд байлгах

1.Асралт гэр бүл нь хүүхдийг гэр бүлийн орчинд асран хамгаалж,

хүмүүжүүлэхдээ тухайн орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллагатай асран хамгаалах тухай гэрээ байгуулна.

Хүүхэд асран хамгаалах тухай гэрээнд дараах зүйлийг тусгана:

- 1.хүүхдийг сурах, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлөөр хангах;
- .2.асран хамгаалагч, асран хамгаалуулагчийн эрх, үүрэг; төрийн холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг;

асран хамгаалагчид олгох урамшуулал, хууль тогтоомжийн дагуу олгогдох бусад тэтгэмж, хөнгөлөлт;

асран хамгаалагчид хууль тогтоомжийн дагуу олгох урамшуулал, бусад тэтгэмж, хөнгөлөлт, олговор;

асран хамгаалуулагчийн эд хөрөнгө; гэрээ дуусгавар болох хугацаа, үндэслэл, бусад үр дагавар.

Хүүхдийг асран хамгаалахад тухайн гэр бүлд тааламжгүй нөхцөл байдал бий болсон нь тогтоогдсон, эцэг, эхэд нь буцаан өгсөн, үрчлүүлсэн бол гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны шаардлагаар, хүндэтгэн үзэх бусад шалтгаан бий болсон бол асран хамгаалагчийн санаачлагаар гэрээг хугацаанаас өмнө цуцалж болно.

.Долоон нас хүрсэн хүүхдийг асран хамгаалуулахаар шийдвэрлэхдээ түүний зөвшөөрлийг нь авна.

Орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга асран хамгаалагчийн үйл ажиллагаанд хяналт тавина.

6.Асралт гэр бүлийн эхнэр, нөхөр нь хүүхдийн эцэг, эх байх эрхийг эдэлж, үүргийг хүлээхгүй.

7.Хүүхдийг асралт гэр бүлд байршуулан өсгөж, хүмүүжүүлэх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.8 дугаар зүйл. Хүүхэд асран хамгаалах гэрээ байгуулж болохгүй хүн

1.Дараах хүнтэй хүүхэд асран хамгаалах гэрээ байгуулахыг хориглоно:

1.1.насанд хүрээгүй;
1.2.эцэг, эх байх эрхээ хасуулсан, хязгаарлуулсан, эсхүл ийм арга хэмжээ авагдаж байсан;

1.3.цагдан хоригдох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан болон зорчих эрхийг хязгаарлах, хорих ял эдэлж байгаа;

1.4.хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан;
1.5.үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхэд хамгааллын үйлчилгээнээс хасагдсан асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асралт бүл;

1.6.хүүхдийг асран хүмүүжүүлэх санхүүгийн чадамжгүй;
1.7.өөрөө асран хамгаалуулж, харгалзан дэмжүүлж байгаа;
1.8.өөрийн буруугаас хүүхэд үрчлэлт нь цуцлагдсан;
1.9.өнгөний болон дархлалын олдмол хомсдол, сүрьеэ, сэтгэцийн өвчтэй;

1.10.архи, согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бодис байнга хэрэглэдэг.

5.9 дүгээр зүйл. Асралт гэр бүлийн саналаа илэрхийлэх эрх

Хүүхэд хамгааллын арга хэмжээг өөрчлөх тухай шийдвэр гарахаас өмнө асралт гэр бүлийн саналыг сонсоно.

5.10 дугаар зүйл. Хүүхдийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах

1.Хүүхдийг төрөл, садан, бусад ойр дотны болон асралт гэр бүлд байлгах арга хэмжээ бүрэн дууссан эсхүл үр дүнд хүрээгүй тохиолдолд хүүхдийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулна.

2.Сум, дүүргийн Засаг дарга эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг Хамтарсан баг, нийгмийн ажилтны санал, дүгнэлтийг үндэслэн гаргаж, шийдвэрийн хэрэгжилтэд хүүхдийн эрхийн ажилтан хяналт тавина.

3.Хүүхдийн төрөлжсөн асрамжийн үйлчилгээний хоол хүнс, хувцас, зөвлөн эдлэл, эм, ариун цэвэр, сургалтын хэрэглэгдэхүүний зардлын хэмжээг санхүү, төсвийн болон хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

4.Хүүхдийн төрөлжсөн асрамжийн үйлчилгээний төсвийг батлуулах, зарцуулах, үйл ажиллагаанд хяналт тавих журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.11 дүгээр зүйл. Шуурхай тусlamжийн үйлчилгээ

1.Хүүхэд хүчирхийлэлд өртсөн, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учирсан, эсхүл учирж болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүүхдэд шаардлагатай шуурхай тусlamжийн үйлчилгээг үзүүлнэ.

2.Хүүхдийн эрх зөрчсөн, эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа талаар мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан тухайн мэдээллийг газар дээр нь шалгах, үнэлэх явцад хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул шууд учирсан, эсхүл уг нөхцөл бүрдсэн, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжигч үйлдсэн, хүүхдийг тухайн орчинд үлдээх боломжгүй нөхцөл үүссэн бол түр тусгаарлах арга хэмжээг нэн даруй авна.

3.Хүүхдийг түр тусгаарлах шийдвэр гарах хүртэл хугацаанд тухайн мэдээ, мэдээллийг хүлээн авсан нийгмийн ажилтан, албан тушаалтан хуульд заасан боломжит арга хэмжээг гэр бүлийн бусад гишүүн, хууль ёсны төлөөлөгчтэй зөвшилцөн хэрэгжүүлнэ.

4.Шуурхай тусlamжийн үйлчилгээний хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээг нэн даруй үзүүлнэ.

5.Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тухайн хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн гэх үндэслэл байгаа бол энэ хуульд заасан тусгаарлах арга хэмжээг аваадаа тэдний зөвшөөрлийг шаардахгүй.

6.Хүүхдийн эрхийн зөрчлийн талаар өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, илрүүлэх зорилгоор яаралтай тусlamжийн 24 цагийн утас ажиллуулна.

7.Шуурхай тусlamжийн үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.12 дугаар зүйл. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

1.Хүүхэд эрсдэлд нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хүүхэд хамгааллын хэрэг (кейс) менежмент, нотолгоонд суурилан боловсруулж, урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлж, үр нөлөөг үнэлнэ.

2.Хүүхэд эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна:

- 2.1.зорилтот бүлэгт чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ;
- 2.2.олон талт, хамтарсан арга хэмжээ;
- 2.3.тодорхой төрлийн арга хэмжээ.

3.Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь төрийн захиргааны төв, нутгийн захиргаа, шүүх эрх мэдэл, болон хууль сахиулах, хяналт шалгалтын чиг үүрэг бүхий байгууллагаас зохион байгуулах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилтай уялдсан байна.

4.Яам, агентлаг болон төрийн бусад байгууллага эрхэлсэн асуудлынхаа хүрээнд хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнд оролцох, сургалт, сурталчилгаа явуулах үүрэгтэй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, САНХҮҮЖИЛТ

6.1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт

1.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл жил бүрийн 3 дугаар улиралд багтаан хүүхэд хамгааллын тайлан гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төрийн захиргааны байгууллагад чиглэл, нутгийн өөрөө

удирдах байгууллага, холбогдох бусад байгууллагад зөвлөмж өгч, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулна.

2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан өөрийн нутаг дэвсгэр дэх хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт, хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, орон нутгийн төсөвт тусган, хэрэгжүүлэх арга хэмжээг авна.

3.Олон улсын байгууллага, магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага, хуулийн этгээдээр хүүхэд хамгааллын чиглэлээр хөндлөнгийн хяналт, шинжилгээ хийлгэж болно.

4. Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллага, бусад хуулийн этгээд нь төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр тандалт, судалгаа хийхийг хориглоно.

5.Орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага хүүхдийн эрхийн хэрэгжилт, хүүхэд хамгааллын чиглэлээр тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын талаар жилд нэгээс доошгүй удаа олон нийтэд тайлагнана.

6.2 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын хяналт, шинжилгээ, үнэлгээ

1.Хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээг үнэлэх зорилгоор төрийн захиргааны байгууллага нь дараах хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ:

1.1.орон нутаг, анхан шатны нэгжээс эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар бүртгэл, судалгааг нэгтгэн дүгнэх;

1.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн талаар бүртгэл, судалгааг Хороо, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагатай хамтран гаргаж, дүн шинжилгээ хийх;

1.3.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн үйлчилгээ, түүний үр дүнг үнэлж, шалгах;

1.4.хүүхэд хамгаалалд төрийн байгууллагуудын оролцоог үнэлэх;

1.5.хүүхэд хамгааллын хүний нөөцийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх, сургалтын чанар, үр нөлөөг үнэлэх;

1.6.Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг өөрөө эсхүл бусад мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх.

6.3 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт

1.Хүүхэд хамгааллын үйлчилгээг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

1.1.улсын төсөв;

1.2.орон нутгийн төсөв;
1.3.хүүхэд хамгааллын үйлчилгээний чиглэлийн үндэсний олон улсын төсөл, хөтөлбөр;

1.4.дотоод, гадаадын хуулийн этгээд болон олон улсын байгууллага, хувь хүнээс өгсөн хандив, тусламж.

2.Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг энэ хуульд заасан төрөл, хэлбэр тус бүрээр улс, орон нутгийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

3.Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг төсөвлөхдөө өмнөх онд шийдвэрлэсэн хүүхэд хамгааллын хэрэг (кэйс)-т тулгуурлаж, дараа онд зарцуулах мөнгөн дүнг тогтооно.

4.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Хамтарсан баг, Хорооны ажил, үйлчилгээний зардал, нийгмийн ажилтны урамшууллыг улс болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

5.Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хуваарилагдсан төсвийг төрийн захиргааны байгууллага, Хороо, Хамтарсан багаас хорооноос хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, тэдэнд хүүхэд хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэсний дараа хяналт тавихтай холбогдох үйл ажиллагаанд зарцуулна.

6.Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын норматив, санхүүжүүлэх аргачлалыг хүүхэд хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

7.1 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1.Хүүхдийн эрхийн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар, хүүхдийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах ял, албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуулиар тус тус тодорхойлно.

2.Энэ хуулийг зөрчсөн нь төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

7.2 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

1.Энэ хуулийг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг